



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгаа, санхүүжилт, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Дээд боловсролын зорилго

2.1.Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино.

3 дугаар зүйл.Дээд боловсролын хууль тогтоомж

3.1.Дээд боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."ахисан түвшний сургалт" гэж магистрын болон докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.2."дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч" /цаашид "суралцагч" гэх/ дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрөөр суралцагч оюутан, магистрын хөтөлбөрөөр суралцагч магистрант, докторын хөтөлбөрөөр суралцагч докторантыг;

4.1.3."судалгааны грант" гэж Инновацийн тухай хуулийн 3.1.7-д зааснаас гадна байгууллага, судлаачийн судалгааны ажилд зориулж иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагаас урьдчилан нөхцөл, болзолжүй олгох мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийг;

4.1.4."судалгааны их сургууль" гэж судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг;

4.1.5."суралцагчийн тэтгэлэг" гэж сургалтын төлбөр, судалгааны болон амьжирагааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан суралцагчид олгох мөнгөн тусламжийг;

4.1.6."сургалтын зээл" гэж сургалтын төлбөр, амьжирагааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцагчид олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.7."сургалтын төлбөрийн хөнгөлөлт" гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг тооцож төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг;

4.1.8."шаталсан сургалт" гэж боловсролын бусад түвшний хөтөлбөрийг зэрэгцсэн болон дараалсан байдлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг.

5 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандaa баримтлах зарчим

5.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь үйл ажиллагаандaa Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;

5.1.2.оюуны бүтээл, судалгааны ёс зүйг дээдлэх;

5.1.3.дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх;

5.1.4.хамтын удирдлагатай, улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллага

6.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь коллеж, дээд сургууль, их сургууль байна.

6.2."Монгол Улсын" болон "Үндэсний" гэсэн үг, түүний англи хэл дээрх орчуулга, барааны тэмдгийг зөвхөн төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад хэрэглэнэ.

6.3.Энэ хуулийн 6.1, 7.4-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг техникийн зохицуулалтад үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

6.4.Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.18-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ.

6.5.Энэ хуулийн 6.1, 7.4-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

6.6.Консерватор нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсрол эзэмшүүлэх шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллага байна.

6.7.Технологийн коллеж нь бүрэн дунд боловсрол, техникийн болон дээд боловсролын шаталсан сургалттай, дэд бакалавр, бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллага байна.

7 дугаар зүйл.Их сургууль

7.1.Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, түршилт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

7.2.Их сургууль нь ахисан түвшний сургалт дагнан эрхэлж болно.

7.3.Их сургууль нь харьялалдаа коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, судалгааны лаборатори, төв, хүрээлэн, ахлах сургууль, дадлагын баазтай байж болно.

7.4.Их сургуулийг үйл ажиллагааны хүрээ, сургалт, судалгааны чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагч, төгсөгчийн тоо, холбогдох бусад үзүүлэлтэд үндэслэн судалгааны, сургалтын, мэргэжлийн гэж ангилна.

7.5.Их сургууль нь сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байж болно.

7.6.Багш бэлтгэх их сургууль нь харьялалдаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

7.7.Соёл, урлаг, цэргийн мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь бүрэн дунд сургуультай /6-12 дугаар анги/ байж болно.

7.8.Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна.

8 дугаар зүйл.Дээд сургууль

8.1.Дээд сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулж, дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгааны байгууллага байна.

8.2.Дээд сургууль нь харьялалдаа коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.

9 дүгээр зүйл.Коллеж

9.1.Коллеж нь дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт-судалгаа, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

9.2.Коллеж нь харьялалдаа политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.

10 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах

10.1.Дээд боловсролын сургалтын байгууллагыг Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу байгуулж зөвшөөрөл олгоно.

10.2.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

10.3.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр харьялалын сургууль байгуулна.

10.4.Дээд боловсролын сургалтын байгууллага татан буугдсан нөхцөлд суралцагчийг ижил мэргэжлийн сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг тухайн сургалтын байгууллагын эцсийн эзэмшигч буюу үүсгэн байгуулагч, Удирдах зөвлөл нь дээд боловсролын бусад байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

10.5.Энэ хуулийн 10.4-т заасантай холбогдон гарах зардлыг татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч, эцсийн эзэмшигч нь хариуцна.

10.6.Татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулах хугацаандaa баталсан шийдвэр, суралцагчийн хувийн хэрэг, мэдээлэл, төгсөгчийн дипломын хуулбар, сургалтын төлөвлөгөө зэрэг дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг татан буугдах шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Үндэсний төв архивт хүлээлгэн өгнө.

10.7.Татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллага төгсөлт хийгээгүй суралцагчийг өөр сургуульд шилжүүлэхдээ түүнийг сургуульд анх элсүүлсэн шийдвэр, судалсан багц цаг, сурлагын дүн, шалгалттай холбоотой материалыг шилжүүлсэн шийдвэрийн хамт шилжин суралцах сургуулийн захиргаанд хүлээлгэн өгнө.

11 дүгээр зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

11.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна.

11.2.Их, дээд сургуульд Эрдмийн зөвлөл, Хөтөлбөрийн хороо, коллежид Сургалт, арга зүйн зөвлөл ажиллана.

11.3.Эрдмийн зөвлөл болон Хөтөлбөрийн хороо, Сургалт, арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн сургуулийн гүйцэтгэх удирдлага батална.

11.4.Анагаах ухааны чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь их сургуулийн эмнэлэгтэй байна.

11.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын харьяаллын сургууль нь хуулийн этгээд байх бөгөөд бие дааж магадлан итгэмжлэл орно.

11.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр орон нутагт салбар сургууль байгуулж болно.

11.7.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын хамтарсан шийдвэрээр аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт, эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэл, дадлагын түшиц газар болгож болно.

11.8.Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг тухайн сургалтын байгууллагын дүрмээр тогтооно.

11.9.Дээд боловсролын сургалтын байгууллага нь дотуур байртай байж болно. Дотуур байранд тавих шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.

11.10.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, сайжруулах дүгнэлт, санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хөтөлбөрийн хороотой байна.

11.11.Энэ хуулийн 11.4-т заасан их сургуулийн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж болно.

11.12.Энэ хуулийн 6.4-т заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь цэрэг, цагдаагийн тогтолцоонд хамаарах анги, байгууллага, цэргийн байртай байна.

12 дугаар зүйл.Дээд боловсролын чанарын баталгаажуулалт

12.1.Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь сургуулийн сургалт, судалгааны гүйцэтгэлийн болон чанарын удирдлагыг сайжруулах зорилготой, нээлттэй, оролцогч талыг хамарсан тасралтгүй үйл ажиллагаа байна.

12.2.Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь дараах хэлбэртэй байна:

12.2.1.дотоод чанарын баталгаажуулалт;

12.2.2.хөндлөнгийн үнэлгээ;

12.2.3.магадлан итгэмжлэл.

12.3.Дээд боловсролын сургалтын байгууллага нь өөрийн үнэлгээ, дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх замаар дотоод чанарын баталгаажуулалтыг хийнэ.

12.4.Хөндлөнгийн үнэлгээг Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, төр, эцэг эх, оюутан, хамтран ажиллагч түнш зэрэг дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцогч талын хүсэлтээр үндэсний, эсхүл олон улсын мэргэжлийн байгууллага, мэргэжлийн холбоо, төлөөллийн бусад байгууллага болон шинжээч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу хийнэ.

12.5.Магадлан итгэмжлэл нь дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарт эрх бүхий байгууллага мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийх үйл явц байна.

12.6.Дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын ерөнхий хуулийн 12.5, энэ хуулийн 12.11-д заасан хөтөлбөр, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 5 жил тутам магадлан итгэмжилнэ.

12.7.Хуульд өөрөөр заагаагүй бол дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөрийн чанар, нийцлийг сайжруулах зорилгоор Боловсролын ерөнхий хуулийн 12.5, энэ хуулийн 12.6-д зааснаас бусад тохиолдолд сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлж болно.

12.8.Шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө тухайн хөтөлбөрт урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэнэ.

12.9.Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг энэ хуулийн 12.13-т заасан цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ.

12.10.Энэ хуулийн 12.2-т заасан хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.11.Анагаах ухааны мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

12.12.Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно.

12.13.Дээд боловсролын цахим мэдээллийн сан нь Боловсролын ерөнхий хуулийн 43.3-т зааснаас гадна магадлан итгэмжлэл, эрдэм шинжилгээний бүтээл, санхүүжилт, иргэний гадаад улсад эзэмшсэн боловсрол, үнэлгээ, хөдөлмөр эрхлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ.

12.14.Энэ хуулийн 12.6-д заасан хугацаагаар турван удаа магадлан итгэмжлэл хийлгэсэн дээд боловсролын сургалтын байгууллага цаашид 10 жил тутам магадлан итгэмжлэл хийлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, НИЙГМИЙН БАТАЛГАА

13 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн эрх, үүрэг

13.1.Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эрхтэй:

13.1.1.судалгааны ажилд оролцох, бусад сургуулийн суралцагч, багштай хамтран судалгаа хийх;

13.1.2.бүтээлээ хэвлүүлэх;

13.1.3.докторантаар суралцах хугацаандаа бакалаврын хөтөлбөрөөр суралцагчдад хичээл заах;

13.1.4.дадлага хийх;

13.1.5.инновац, шинэ мэдлэгийг хөгжүүлэх;

13.1.6.хичээлийн хөтөлбөр болон багшийг сонгох;

13.1.7.улиралд судлах багц цагийг сонгож, суралцах хугацааг төлөвлөх;

13.1.8.ижил түвшний бусад сургуулийн хичээл болон багшийг сонгон суралцах, багц цагийг дүйцүүлэх;

13.1.9.хуульд заасан бусад.

13.2.Суралцагч нь дараах үүрэгтэй:

13.2.1.хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмших, бие даан суралцах;

13.2.2.сургуулийн дотоод дүрэм, журмыг мөрдөх;

13.2.3.сургалтын төлбөрийг гэрээний дагуу төлөх;

13.2.4.хуульд заасан бусад.

14 дүгээр зүйл.Суралцагчийн нийгмийн баталгаа

14.1.Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

14.1.1.стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хичээлийн байр, лаборатори, номын сан, нийтийн хоол, биеийн тамирын заал, талбайгаар үйлчлүүлэх;

14.1.2.сургалтын зээл авах;

14.1.3.суралцагчийн тэтгэлэгт хамрагдах;

14.1.4.хууль тогтоомжид заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх;

14.1.5.хуульд заасан бусад.

15 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш

15.1.Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нь докторын зэрэгтэй байна.

15.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

15.3.Дээд боловсролын сургалтын байгууллагад семинар, дадлага, лабораторийн хичээлийг тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх, дадлага, туршлагатай мэргэжилтэн удирдаж болно.

15.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлтэй байна.

15.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ.

16 дугаар зүйл.Багшийн эрх, үүрэг

16.1.Багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эрхтэй:

16.1.1.эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл авах;

16.1.2.бүтээлийн чөлөө авах;

16.1.3.зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

16.1.4.эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, технологи, инновацийн бүтээгдэхүүн, оюуны өмчөө хамгаалуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах.

16.2.Багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах үүрэгтэй:

16.2.1.мэргэжлээрээ нийгэмд үйлчлэх, соён гэгээрүүлэх, сурталчлах ажилд оролцох;

16.2.2.байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр чанарын баталгаажуулалт, сургалтын хөтөлбөрийн сайжруулалтад оролцох;

16.2.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх.

17 дугаар зүйл.Багшийн нийгмийн баталгаа

17.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

17.1.1.өөрийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд байгуулагдсан гарааны компанийн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогоос хувь, ногдол ашиг хүртэх;

17.1.2.мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг авах;

17.1.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх боломж, орчин, нөхцөлөөр хангагдах.

17.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тухайн ажиллаж байгаа байгууллагаас дараах дэмжлэгийг үзүүлж болно:

17.2.1.орон нутаг дахь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилтанд орон нутагт тогтворт суурьшилтай ажилласны тэтгэмжийг 5 жил тутамд нэг удаа олгох;

17.2.2.дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшид Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16.1.2-т заасан тэтгэмж олгох.

17.3.Энэ хуулийн 17.2.1, 17.2.2-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг тухайн сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, АГУУЛГА

18 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт

18.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн шаардлага хангасан хүний элсүүлнэ.

18.2.Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэхэд энэ хуулийн 18.1 дэх хэсэг хамаарахгүй.

18.3.Боловсролын ерөнхий хуулийн 26.1.22, энэ хуулийн 18.8-д заасан үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.4.Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн шалгалтын босго оноог өмчийн хэлбэр харгалзахгүйгээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ижил хэмжээгээр тогтооно.

18.5.Элсэлтийн шалгалтын босго оноог шинэчлэхэд өмнөх босго оноог бууруулахгүйгээр тогтооно.

18.6.Дээд боловсролын сургалтын байгууллага мэргэжил эзэмшихэд шаардагдах мэдлэг, ур чадварыг харгалзан элсэлтийн

нэмэлт шалгалт зохион байгуулж болно.

18.7.Ахисан түвшний сургалтад элсэгч, суралцагчид тавих шаардлага, элсэлтийн шалгалтыг сургуулийн дотоод журмаар зохицуулна.

18.8.Элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, үнэлгээний арга зүйг олон улсын чиг хандлагад нийцүүлнэ.

19 дүгээр зүйл.Сургалтын зохион байгуулалт

19.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь танхмын, танхмын бус, тэдгээрийн хосолсон хэлбэрээр сургалт зохион байгуулна.

19.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалт, судалгаа, туршилтын ажлын зарим хэсгийг эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрийн лаборатори, дадлагажих газрыг түшиглэн явуулж болно.

19.3.Дээд боловсролын хичээлийн жил нь улиралд хуваагдах бөгөөд 2-4 улиралтай байж болно. Суралцах хугацааг элсэлтийн шалгалттай уялдуулан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохицуулна.

19.4.Суралцагч элссэн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт суралцах хугацаанд бусад мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт давхар суралцаж хос мэргэжил эзэмшиж болно.

19.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

19.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь төгсөгчийн мэргэжлийн хөгжлийг хангах, насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

19.7.Дээд боловсролын сургалтын байгууллага нь бие даан, эсхүл хамтран цахим сургалтын системийг бүрдүүлэн, сургалт зохион байгуулж болно.

20 дугаар зүйл.Сургалтын хөтөлбөр, агуулга

20.1.Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, энэ хуулийн 20.1-д заасан нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

20.3.Сургалтын хөтөлбөрийг тухайн сургалтын байгууллага боловсруулж, энэ хуулийн 11.2-т заасан хорооны дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэх удирдлага батална.

20.4.Сургалтын хөтөлбөрийн агуулга нь харилцан уялдаа холбоотой ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсэгтэй байна.

20.5.Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна доор дурдсан агуулгыг тусгана:

20.5.1.ерөнхий суурь хэсэгт дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил;

20.5.2.мэргэжлийн суурь хэсэгт суралцах чиглэлийн шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэх, бүтээлчээр сэтгэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголт;

20.5.3.мэргэших хэсэгт тодорхой мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, тухайн салбар, чиглэлийн шинжлэх ухаан, арга, технологи.

20.6.Дээд боловсролын түвшин нь багц цагаар хэмжигдэх дэд бакалаврын, бакалаврын, магистрын, докторын зэрэгтэй байна.

20.7.Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт 90 багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй, магистрын зэрэгт 30 багц цагаас доошгүй, докторын зэрэгт 60 багц цагаас доошгүй байна.

20.8.Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.9.Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн хүсэлтээр энэ хуулийн 20.1-д заасан нийтлэг шаардлагын дагуу бакалавр-магистрын 150-иас, магистр-докторын 90-ээс доошгүй багц цаг бүхий нэгдмэл агуулгатай хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

20.10.Энэ хуулийн 20.9-д заасан нэгдмэл хөтөлбөрөөр суралцсан төгсөгчид тухайн түвшин бүрийн боловсролын баримт бичгийг олгоно.

20.11.Бакалаврын хөтөлбөрт суралцаж 90 багц цаг судалсан боловч цаашид суралцах боломжгүй болсон суралцагчид дэд бакалаврын зэрэг олгоход тавих шаардлагыг хангасан тохиолдолд тухайн боловсролын баримт бичгийг дүйцүүлэн олгож болно.

20.12.Боловсролын ерөнхий хуулийн 3.1.4-т заасан багц цаг нь дээд боловсрол эзэмшихэд тавих шаардлага, сургалтын төлөвлөгөө, төлбөр, багшийн ажлын ачаалал зэргийг тогтоох үндэслэл болно.

20.13.Боловсролын ерөнхий хуулийн 26.1.7-д заасан дээд боловсролын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индексийн жагсаалтыг

5 жил тутам шинэчлэн батална.

20.14. Сургалтын хөтөлбөрийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчийн төлөөллөөс бүрдсэн энэ хуулийн 11.2-т заасан Хөтөлбөрийн хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

20.15. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад хөтөлбөрийн агуулга, багц цаг дүйцүүлэн тооцож болно.

21 дүгээр зүйл. Суралцагчийн үнэлгээ, төгсөлт

21.1. Суралцагчийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах үйл ажиллагаа, бүтээлч хандлагыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлж урамшуулахад чиглэнэ.

21.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын онцлогоос хамааран суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан амжилтыг багц цагт тооцож болно.

21.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл ажиллагааг энэ хуулийн 21.3-т заасан журмаар Боловсролын ерөнхий хуулийн 17.11-д заасан байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөлөл хамтран хэрэгжүүлнэ.

21.5. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид диплом олгох, хүчингүй болгох, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчийн дипломыг хүлээн зөвшөөрөх, бүртгэх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг Боловсролын ерөнхий хуулийн 26.1.22-т заасан журмаар зохицуулна.

21.6. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулах ба докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ

22 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаа

22.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаа эрхэлж, гарсан үр дүнг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

22.2. Дээд боловсролын сургалтын байгууллага нь эдийн засаг, нийгмийн тэргүүлэх чиглэлээр болон ахисан түвшний хөтөлбөрийн холбогдох чиглэлээр бие дааж болон хамтарсан төсөл хэрэгжүүлнэ.

22.3. Дээд боловсролын сургалтын байгууллага нь оюуны өмчийг бүртгүүлэх, хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах технологи дамжуулах бүтцийг бий болгож, их сургууль, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжсэн тогтолцоог бүрдүүлсэн байна.

22.4. Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор их сургууль нь өөрийн үндсэн бүтцэд эрдэм шинжилгээний хүрээлэн, сургалт, судалгааны, бизнес инкубатор, технологи дамжуулах төв, гарааны компани, шинжлэх ухааны парк, технологи, инновацын кластер, туршилт үйлдвэрлэлийн болон эдгээртэй адилтгах нэгжийг бие даан, эсхүл хамтран байгуулж болно.

22.5. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн хүрээнд багш, суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг үнэлж, багшийн нэмэлт орлого олох, суралцагчийн сургалтын төлбөрийг хөнгөлөх эх үүсвэр болгон ашиглаж болно.

22.6. Суралцагчийг эрдэм шинжилгээний үр чадвараа хөгжүүлэх, гүнзгийрүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх профессорын багт ажиллуулж, хамтран ажиллах боломжоор хангана.

22.7. Энэ хуулийн 22.4-т заасан нэгж нь удирдлага, санхүүгийн бие даасан үйл ажиллагаа явуулах ба холбогдох журмыг Дээд боловсролын Үндэсний зөвлөлөөс баталсан нийтлэг журам, бусад хууль тогтоомжид нийцүүлэн тухайн сургуулийн Удирдах зөвлөл батална.

22.8. Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23 дугаар зүйл. Судалгааны ёс зүй

23.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, суралцагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглахтай холбогдох үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн сан хариуцна.

23.2. Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23.3. Дээд боловсролын судалгааны ёс зүйг Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Судалгааны ёс зүйн дэд хороо

хариуцна.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан дэд хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.4.1.судалгааны ажилд оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх журам, заавар, зөвлөмж боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.4.2.судлаачийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан хэлэлцэх, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

24 дүгээр зүйл.Дээд боловсролын удирдлага

24.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 23.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

24.2.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.2.1.төрийн захиргааны бусад байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах;

24.2.2.төрийн захиргааны бусад байгууллага болон дотоод, гадаадын байгууллага, иргэнтэй санхүүгийн дэмжлэг олгох, суралцагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах;

24.2.3.судлаачид эрдмийн зэрэг, цол олгох нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох.

24.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх харьяа нэгжтэй байж болно.

24.4.Энэ хуулийн 24.3-т заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25 дугаар зүйл.Дээд боловсролын зөвлөл

25.1.Дээд боловсролын салбарт Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөл нь Дээд боловсролын зөвлөл байна.

25.2.Дээд боловсролын зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгааны үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

25.3.Зөвлөл нь төрийн, дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгж, оюутны төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.

25.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Боловсролын ерөнхий хуулийн 23.5-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөл

26.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага нь Удирдах зөвлөл байна.

26.2.Удирдах зөвлөл нь эцсийн өмчлөг буюу үүсгэн байгуулагч, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

26.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл найм, багшийн төлөөлөл гурав, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл гурав, суралцагчийн төлөөлөл нэг байна.

26.4.Удирдах зөвлөл нь энэ хуулийн 26.8-д заасан нийтлэг дүрэмд нийцүүлэн өөрийн дүрмийг батална.

26.5.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн энэ хуулийн 26.3-т заасан төлөөллийн оролцоог хангасан байна.

26.6.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага дундын Удирдах зөвлөл байгуулж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 26.3-т заасан төлөөллийг оролцуулсан байна.

26.7.Энэ хуулийн 26.6-д заасан Удирдах зөвлөл байгуулах тохиолдолд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

26.8.Энэ хуулийн 26.1-д заасан Удирдах зөвлөлийн даргыг сонгох, гишүүнээр ажиллах, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох, дарга, гишүүнийг эгүүлэн татахтай холбогдсон харилцааг зохицуулах нийтлэг дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн чиг үүрэг

27.1.Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухайн дээд боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлэх урт, дунд,

богино хугацааны бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, хөтөлбөрийг батлах, өөрчлөх;

27.1.2.дээд боловсролын сургалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, тухайн жилийн төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;

27.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив, тусламж авах журам тогтоох, зарцуулалтад хяналт тавих;

27.1.4.сургалтын төлбөр, оюутны үйлчилгээний зардал, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу төрөөс хараат бусаар тогтоох;

27.1.5.дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

27.1.6.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан, сургуулийн үйл ажиллагааны тайланд хийсэн дүгнэлтийг үүсгэн байгуулагчид танилцуулах;

27.1.7.нээлттэй сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг 5 жилийн хугацаагаар томилж, гэрээ байгуулах, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

27.1.8.гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх, гэрээ дүгнэх журмыг батлах, өөрчлөх;

27.1.9.гүйцэтгэх удирдлагын гэрээг жил бүр дүгнэж, үр дүнг үндэслэн сунгах эсэхийг шийдвэрлэх;

27.1.10.дээд боловсролын үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх, үр дүнг тайлagna.

27.2.Удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэг байгуулж болно.

28 дугаар зүйл.Эрдмийн зөвлөл

28.1.Эрдмийн зөвлөл нь 21-ээс доoshгүй гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүнээр эрдмийн зэрэг, цолтой багшийг үндсэн орон тооны нийт багш нарын төлөөллөөс сонгоно.

28.2.Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

28.2.1.сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

28.2.2.дэд профессор, профессор, хүндэт цол олгох;

28.2.3.судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх.

28.3.Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

28.4.Эрдмийн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.

29 дүгээр зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага

29.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь дээд сургууль, коллежид захирал /цаашид "захирал" гэх/, их сургуульд ректор /цаашид "ректор" гэх/ байна.

29.2.Захирал, ректорыг гэрээний биелэлт, үр дүнг үндэслэн нэг удаа улируулан томилж болно.

29.3.Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг хууль зүй, дотоод хэргийн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

29.4.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг

30.1.Гүйцэтгэх удирдлага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

30.1.1.дээд боловсролын сургалтын байгууллагыг улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, чиглэл, хөтөлбөрийг санаачлан Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг хангах;

30.1.2.гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах;

30.1.3.байгууллагын стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийн чанар, үр дүнг бүрэн хариуцах;

30.1.4.санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж, санхүү, төсвийг үр дүнтэй төлөвлөж зарцуулах;

30.1.5.сургуулийн хөгжлийг дэмжихэд үр нөлөөтэй, хөгжихүйн болон чадахуйн /мерит/ зарчмыг хангасан засаглал, менежментийн тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх;

30.1.6.хүний нөөцийг чадавхжуулах, өндөр мэдлэг үр чадвартай мэргэжилтнийг татан ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн хүний нөөцийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, багш, ажилтны нийгмийн баталгааг хангах;

- 30.1.7.дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 30.1.8.багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад ажилтны орон тоо, цалингийн сүлжээг баталж, сонгон шалгаруулалтыг чадахуйн /мерит/ болон хөгжихүйн зарчимд үндэслэн явуулж, томилох;
- 30.1.9.гүйцэтгэх удирдлагын чиг үүрэгтэй холбогдсон бусад харилцааг сургуулийн дүрмээр зохицуулна.

31 дүгээр зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын чиг үүрэг

- 31.1.Дээд боловсролын сургалтын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 31.1.1.дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац, сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий этгээдийн баталсан бодлого, стратеги төлөвлөгөө, дүрэм, журмыг чанартай хэрэгжүүлэх, тайлагнах;
- 31.1.2.сургуулийн дотоод үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг батлан хэрэгжүүлэх;
- 31.1.3.сургалтын хөтөлбөр, агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэлийг тодорхойлж, чанартай хэрэгжүүлэх;
- 31.1.4.зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгаа, хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, оролцох;
- 31.1.5.элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах;
- 31.1.6.тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- 31.1.7.багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, технологийн судалгаа хийх;
- 31.1.8.сургуулийн үйл ажиллагаа, сургалтад цахим технологи нэвтрүүлэх;
- 31.1.9.гадаад, дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах;
- 31.1.10.багш, ажилтан, суралцагчийг соён гэгээрүүлэх, олон нийтийн болон хүмүүнлэгийн чиглэлийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлэх;
- 31.1.11.багш, ажилтан, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;
- 31.1.12.амжилттай суралцаж, олон нийтийн болон хүмүүнлэгийн бүтээлч ажил гүйцэтгэсэн суралцагчид тухайн сургалтын байгууллага тэтгэлэг олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг сургуулийн дүрэмд тусган хэрэгжүүлэх;
- 31.1.13.аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөр, амьжиргааны зардлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дэмжлэг үзүүлэх;
- 31.1.14.статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.
- 31.2.Дээд боловсролын сургалтын байгууллага доор дурдсан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй:
- 31.2.1.олон улсад өрсөлдөх чадвартай багшлах хүний нөөцийг бэлтгэх, дэмжих;
- 31.2.2.онцгой авьяастай суралцагчийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 31.2.3.дээд боловсролын сургалтын байгууллага хооронд харилцан тохиролцсон бусад хэлбэр.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ

32 дугаар зүйл.Дээд боловсролын санхүүжилт

- 32.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
- 32.1.1.үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;
- 32.1.2.олон улсын байгууллага, хөрөнгө оруулалтын сангаас олгох хөгжлийн тусlamж, хандивын хөрөнгө;
- 32.1.3.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хэрэгжих төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 32.1.4.дээд боловсролын сургалтын байгууллагын дэргэд байгуулсан гарааны компанийн үйл ажиллагаанаас орсон орлого;
- 32.1.5.технологи дамжуулалт, патент, ашигтай загвар, роялти, зөвлөх үйлчилгээнээс олсон орлого, гэрээт ажил, үйлчилгээ, түрээс, аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого;
- 32.1.6.сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орох орлого;

- 32.1.7.хүүгийн орлого;
- 32.1.8.байгууллагын болон судалгааны грант;
- 32.1.9.өрсөлдөөнт төсөл;
- 32.1.10.их сургуулийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс олсон орлого;
- 32.1.11.хөрөнгө оруулалтын зээл;
- 32.1.12.орон нутгийн төсвийн дэмжлэг;
- 32.1.13.хуульд заасан бусад эх үүсвэр.
- 32.2.Дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дараах дэмжлэг үзүүлнэ:
- 32.2.1.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг;
- 32.2.2.улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал;
- 32.2.3.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал.
- 32.3.Энэ хуулийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.4, 32.1.5, 32.1.6, 32.1.7, 32.1.8, 32.1.9, 32.1.10, 32.1.11, 32.1.12, 32.1.13-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогыг захиран зарцуулах журмыг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөл батална.
- 32.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 32.5.Энэ хуулийн 6.6-д заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь хуулиар зөвшөөрсөн нийтлэг санхүүжилтийн эх үүсвэрээс гадна үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл, онцлогоос хамаарч улсын төсвийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй байж болох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.
- 32.6.Аймаг, нийслэлийн удирдлага дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид хуульд заасан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.
- 32.7.Энэ хуулийн 32.2-т заасан зардлыг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлнэ.
- 32.8.Энэ хуулийн 32.2-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

33 дугаар зүйл.Бие даасан санхүүгийн үйл ажиллагаа

- 33.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь санхүү, төсвийн хувьд бие даасан байдлаа хадгалах талаар дараах үйл ажиллагаа эрхэлнэ:
- 33.1.1.оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор өөрийн үндсэн бүтцэд харьялагдах сургалт, судалгааны бизнес инкубатор, технологи дамжуулах төвийг дангаар болон үйлдвэрлэлийн иж бүрдэл тогтолцоогоор байгуулан ажиллуулах;
- 33.1.2.хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, сургалтын материаллаг орчныг сайжруулах зорилгоор зээл авах;
- 33.1.3.сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орлого олох;
- 33.1.4.дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

34 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 34.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 34.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР